

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.12.20

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	ХЭРЭГЖИЛТ	Хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго: 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2021 онд 40,23-аас доошгүй хувьд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2020 оноос ахиулан 2021 онд 239,515.25 сая төгрөгт хүргэх.							
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх	ОНТ-3,0	Дутагдалтай боловсон хүчний хангалтын хувь	44	44	ХХААСалбарын мэргэжилтэй боловсон хүчин 57 байхаас 30 албан хаагч ажиллаж, 2 мэргэжилтэн шинээр ажилд орж боловсон хүчний хангамж 52,6 хувьтай болсон. Сумдын ХААТасгийн мэргэжилтний хангалт 40 хувьтай байна. Дундговь аймгийн ХХААСалбарын хангалт 46,3 %-тай байна.	100
		0	Тухайн салбарт 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж буй төрийн албан хаагчдын тоо	23	24	ХХААГазарт 11, сумдын ХААТасагт 17 албан хаагч, нийт 28 албан хаагч ХХААСалбарт 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа нь нийт албан хаагчийн 93,3 хувийг эзэлж байна.	
1.1	Орон нутагт дутагдалтай мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулах	ОНТ-3,0	Оюутны тоо	1	2	Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд “Мал зүйч” мэргэжлээр суралцаж буй оюутан М.Балжиннямд сургалтын төлбөрт 3,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	50

1.2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, үр дүнг тооцон ажиллах.	УТ-3,5 сая	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95	95	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 оны төлөвлөөг 98,5 хувьтай хэрэгжүүлэн ажилласан.	100
2	Авилгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	0	Хувь	100	100	Авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 11 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 100 %-тай хэрэгжсэн.	100
2.1	Удирдах албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргаж ил тод мэдээллэх	0	Мэдээлсэн тоо	2	1	ХАСХОМ гаргадаг 5 албан хаагчийн хамаарал бүхий 15 этгээдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргаж ил тод мэдээллэн ажилласан.	100
2.2	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна. 31 мэдэгдэл тайлбарыг гаргуулан системд бүртгэсэн байна. АТГ-аас ирүүлсэн 8 видео, 4 мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн байна.	100
3	Байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах	УТ-0,5	Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн хувь	94,5	95	Байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх 2 зорилт 5 арга хэмжээг 97,5 %-тай хэрэгжүүлсэн.	100
		0	Нэвтрүүлсэн цахим арга хэмжээнүүдийн тоо	0	1	ERP систем, E-mongolia УТҮГазраас 03 сарын 23-ны өдөр зохион байгуулсан сургалтад 5 албан хаагч хамрагдаж шалгалтаа онлайнаар өгч тэнцсэн.	

						Энэ онд цаг бүртгэл болон албан бичиг цэсийг шинээр ашиглаж хэвшсэн	
3.1	Төрийн албан хаагчдыг “Монгол бичиг” дунд шатны сургалтад хамруулах	УТ-0,3	Хамрагдсан албан хаагчдын тоо	18	18	Монгол бичгийн сургалтад тус байгууллагын нийт 18 албан хаагч суралцаж анхан шатны батламжаа авсан ба дунд шатны сургалтад өөрсдийн боломжоо ашиглан хувиараа суралцаж байна.	100
3.2	Албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлж байгууллагын дотоод сургалтыг сайжруулах	УТ-0,3	Зохион байгуулсан сургалтын тоо	22	26	Байгууллагын дотоодын зохион байгуулсан сургалтад 11 сарын байдлаар 11 албан хаагч төлөвлөгөөний дагуу 28 төрлийн сургалтыг зохион байгуулж бүх албан хаагчид хамрагдсан. Мөн Мал үржлийн албанаас санаачилан байгууллагын бүх албан хаагчдаа соён гэгээрүүлэх, номонд дуртай болгох үүднээс “Өглөөний гайхамшиг” 10 хоногийн номын уншлага арга хэмжээг зохион байгуулж амжилттай оролцсон 2 албан хаагчийг шалгаруулж шагнаж урамшуулсан.	100
3.3	Төрийн албан хаагчдыг орон зай, цаг хугацаанаас үл хамааран богино болон дунд хугацааны сургалтад бүрэн хамруулж мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.	УТ-1,0	Хамрагдсан албан хаагчдын тоо	200	150	Байгууллагын албан хаагчид богино болон дунд хугацааны сургалтад танхимаар-19, цахимаар-35 нийт 54-н удаагийн сургалтад, давхардсан тоогоор 201 албан хаагч хамрагдаад байна.	100

4	Цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлэх	0	Нэвтрүүлсэн цахим арга хэмжээнүүдийн тоо	0	1	ХХААХҮЯ-аас Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн санг ашиглалтанд оруулан албан хаагчид болон нэгж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг журмын хугацаагаар тайлагнаж хэвшсэн. Энэ онд цаг бүртгэл болон албан бичиг цэсийг шинээр ашиглаж хэвшсэн	100
4.1	Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх	0	Нэгдсэн системийг нэвтрүүлсэн эсэн тийм-1 үгүй-0	0	1	ХХААХҮЯ-аас Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн санг ашиглалтанд оруулан албан хаагчид болон нэгж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг журмын хугацаагаар тайлагнаж хэвшсэн.	100
4.2	E-mongolia системийн ашиглалтыг нэмэгдүүлэх	0	Албан хаагчдын ашиглалтын хувь	0	100	Албан хаагч бүр E-mongolia-г албан болон хувийн хэрэгцээндээ ашиглаж байна.	100
		0	Зохион байгуулсан сургалтын тоо	0	1	ERP систем, E-mongolia УТУГазраас 03 сарын 23 өдөр зохион байгуулсан сургалтад 5 албан хаагч хамрагдаж шалгалтаа онлайнаар өгч тэнцсэн. Цахим аймаг Дундговь E-Mongolia арга хэмжээний нээлтэнд байгууллагын нийт албан хаагч нар 03 сарын 25 өдөр хамрагдсан. Мөн 11 сарын 21-нд ХХААГ-ын нийт 13 албан хаагчдад аймгийн ЗДТГ-ын мэдээллийн технологийн	

						мэргэжилтэн Н.Мөнгөн ERP системийн ашиглалтын талаар сургалт мэдээлэл хийсэн. 11 сард болсон E-mongolia системийн талаарх сургалтад тус байгууллагын 2 албан хаагч хамрагдсан.	
4.3	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг баяжуулж, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэх.	0	Мэдээний тоо	67	40	Жилийн эцсийн байдлаар байгууллагын цахим хаягт цаг үетэй холбоотой мэдээ мэдээлэл, төсөв санхүү, хүний нөөцтэй холбоотой нийт 63, page, facebook хуудсаар 43 мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй ил тод байршуулж ажилласан.	100
5	Орон нутгийн мах, сүү сүүн бүтээгдэхүүний хэмжээг 2021 онд 421 тн байсныг 2022 онд 35 тн-р нэмэгдүүлэн нийт 456 тн болгон хангамжийн хувийг 27,8 хувьд хүргэнэ.	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Үйлдвэрлэлийн хэмжээ Тн	421	456	Сайнцагаан суманд үйл ажиллагаа эрхэлдэг “ЭЭТМО” ХХК, “Их Хайрхан Мандал” ХХК-ны мал төхөөрөх цехэд 341.8 тн мах, мөн тус сумын бууз баншны үйлдвэрлэл эрхэлдэг 4 иргэн 18 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт 459,3 тн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. -Мандалговь Хүнс ХХК нь 7.4 тн сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж зах зээлд нийлүүлсэн байна. -Төлөвлөгөөт мах сүүний 27,2 хувийг хангасан байна.	86,3
5.1	Мал төхөөрөх цехэд бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнийг хүн амын хэрэгцээнд нийлүүлэх	ОНТ-150,0	Бэлтгэсэн махны хэмжээ /тн/	418,5	452	Сайнцагаан сумын ЭЭТМО ХХК, Их Хайрхан Мандал ХХК-ны мал төхөөрөх цехэд 341,8 тн мах бэлтгэж орон нутгийн болон	0

						нийслэлийн хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байна. Мөн Хоршоо хөгжүүлэх сангаас Сайнцагаан сумын Баянзэгстэй ХХК “Дайвар бүтээгдэхүүн ангилж савлах”, үйлдвэрлэлд 100 сая, Сайхан-Овоо сумын “Их бадрах хайрхан” ХХК “Мал төхөөрч мах, махан бүтээгдэхүүн” боловсруулах жижиг үйлдвэрлэлд 50 сая төгрөгний санхүүжилтийг тус тус олгоод байна.	
5.2	Боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх	Хувийн хэвшил	Нийлүүлсэн сүүний хэмжээ /тн/	2,5	4	Мандалговь хүнс ХХК 7,4 тн шингэн сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн стандартын шаардлагад нийцсэн сав баглаа боодол, хаяг шошготойгоор хүн амын хэрэгцээнд нийлүүлж байна.	100
6	Орон нутгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээний 23 хувийг хангана.	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Хангамжийн хувь	19	23	Аймгийн нийт хүн ам буюу жишсэн дундаж хүн амд төмс 1674,7 тн, хүнсний ногоо 3628,5 тн тус тус хэрэгцээтэйгээс төмсний 14,2, хүнсний ногооны 5 хувийг, нийт 19,2 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан байна.	50
6.1	Тариалан эрхлэгч нарт технологийн сургалт зохион байгуулах	ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Сургалтын тоо	2	1	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон "Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв", Жайка ОУБ-хамтран Хүнсний ногоо тариалах, ногооны аж ахуйг	100

						хөгжүүлэх SHEP арга сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад 11 сумын хүнсний ногооны хангамжийг сайжруулах, хүнсний ногоо тариалах сонирхолтой 66 тариалан эрхлэгч нар хамрагдсан.	
6.2	Тариалан эрхлэгч нарт хөнгөлөлттэй үрийг нийлүүлэх	УТ, Хувийн хэвшил	Хүнсний ногооны үрийн нэр, төрөл	9	10	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хаврын тариалалтанд зориулан 80 хувийн хөнгөлөлттэй олгосон 3.111.726 төгрөгний өртөг бүхий төмс хүнсний ногооны 20 нэр төрлийн 2.6 тн үрийг 15 сумын 150 тариаланчдад олголоо.	100
			Олгосон үрийн хэмжээ/кг/	146,2	150		
			Мөнгөн дүн /сая.төг/	2,4	2,6		
6.3	Төмс тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Тариалсан талбайн хэмжээ /га/	28	30	Төмс 29.4 га-аас 234,4 тн-ийг хураан авсан байна.	50,5
			Хураан авсан ургацын хэмжээ /Тн/	233	274		
6.4	Хүнсний ногоо тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Тариалсан талбайн хэмжээ /га/	19,5	20,5	Хүнсний ногоо 21,5 га-аас 176,2 тн-ийг хураан авсан байна.	100
			Хураан авсан ургацын хэмжээ /тн/	162,3	170		
7	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж,	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр,	Үйлдвэрийн тоо	49	2	2022 онд ЖДҮХС, ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 2022 онд нийт 18 төсөлд 1032,0 сая төгрөгийн зээлийг олгосон ба үүний үр дүнд	100

	жижиг дунд, хөнгөн, хүнсний үйлдвэрийн тоо 2021 онд 49 байгааг 2022 онд 51 болгоно.	Хувийн хэвшил				шинээр 5 үйлдвэр, 37 ажлын байр бий болоод байна. Тухайлбал: Өлзийт сумын Буян булаг өрнөх хоршоо эсгийний үйлдвэр, Сайхан-Овоо сумын Их бадрах хайрхан хоршоо мал нядалгааны цех, Адаацаг сумын Ихэр улааны цохио, Сайнцагаан сумын “Хишиг өгөөмөр” ХХК сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, Говь-Угтаал сумын Үржих эрдэнэ дэвжих ХХК туслах аж ахуй хөгжүүлэхээр дэмжлэг авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.	
7.1	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах борлуулалтын цэгийн орлогыг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Борлуулалтын орлогын өсөлт /Сая.төг/	200	220	Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, зах зээлд зуучлах “Дундговьд үйлдвэрлэв” төв Орон нутгийн төсвийн болон ЗЗББУТ-ийн 419,0 гаруй сая төгрөгийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орлоо. Уг борлуулалтын төвтэй болсноор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, идэвхжүүлэх, сурталчлах, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг шимтгэлгүйгээр борлуулах боломж бүрдэж өнөөгийн байдлаар 142,0 сая төгрөгийн борлуулалт хийжээ.	50
7.2	Орон нутгийн онцлогтой хоршоодыг байгуулахад арга	Хувийн хэвшил	Зохион байгуулсан сургалтын тоо	1	2	Сумдын мэргэжилтнүүд болон давхардсан тоогоор нийт 1800 гаруй хоршоо, малчдын төлөөлөлд	100

	зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулах					“Хоршооны тухай хуульд орсон гол өөрчлөлтүүд”, “Хоршооны тухай хууль, холбогдох журмын дагуу хоршоодыг шинэчлэн бүртгэх тухай”, “Хоршооны гишүүний болон сумын засаг даргын эрх, үүрэг, хариуцлага”, “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, “Хоршооны дүрмийн өөрчлөлт, улсын шилдэг хоршоо шалгаруулах журам” зэрэг сэдвийн хүрээнд танилцуулга, мэдээлэл олгох 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, шинээр хоршоо болох 10 гаруй иргэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээд байна. Үүний үр дүнд 2022 онд Ажирхайн оргил, Их бадрах хайрхан, Онги нутгийн буян, Загийн алим эко, Голын цагаан овоо, Гурван өндрийн шим хоршоод шинээр байгуулагдсан байна.	
7.3	Өлзийт сумын ингэний фермерийн аж ахуйн сүүг үйлдвэрт нийлүүлэх хэмжээг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Саалинд хамрагдах ингэний тоо Тухайн жилд нийлүүлсэн сүүний хэмжээ /тн/	70	90	Өлзийт сумын 4 малчин өрхөд 1 ээлжийн 50 ингийг түрээсийн гэрээгээр маллуулж эхний хагас жилийн дүнгээр 800 литр сүүг зах зээл нийлүүлээд байна.	50
				2,5	4		

7.4	Хүнс, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлтийн чиглэлээр гадаадын төсөлтэй хамтран ажиллах	Төсөл хөтөлбөр	Хэрэгжиж эхлэсэн төслийн тоо	0	1	Япон улсын хамтын ажиллагааны Жайка төслөөс ЕБС-ийн “Үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих” төсөл, “SHEP” Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр, Дэлхийн банкны Мерит төслөөс Жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих төсөл, Европын холбооны IPAD буюу Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл тус тус хэрэгжиж байна.	100
8	Малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн дэд системүүдэд баяжилт хийх	ОНТ, Хувь хөрөнгө-5,0	Тухайн жилд ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн малын тоо	20070	14570	Ялган тэмдэгжүүлсэн 6400 малыг бүртгэл мэдээллийн санд бүртгэж байна. Бүртгэлжүүлэх ажил 60%-тай явагдаж бөгөөд энэ ондоо бүх малын мэдээлэлийг бүрэн оруулна.	50
8.1	Үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч болон таваарын малыг ялган тэмдэглэх	ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувь хөрөнгө-15,0	Ээмэгжүүлсэн малын тоо	20070	2500	Үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч болон таваарын 6400 малыг ялган тэмдэглэсэн.	100
8.2	Үржлийн хээлтүүлэгч бух, ухна, хуцыг удам зүйн үнэлгээний программд бүртгэх	0	Программд бүртгэсэн малын тоо	0	Бух-150, Хуц-1500 Ухна-750	Удам зүйн үнэлгээний программын шинэчлэгдэж байгаа тул малын бүртгэл хийгдээгүй байна	0
8.3	Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программд бүртгэх	0	Тухайн жилд мэдээллийн санд бүртгэсэн малын тоо	0	14570	Ялган тэмдэгжүүлсэн 6400 малыг бүртгэл мэдээллийн санд бүртгэж байна. Бүртгэлжүүлэх ажил 60%-тай явагдаж бөгөөд энэ ондоо бүх малын мэдээлэлийг бүрэн оруулна.	50

9	20 мян.га бэлчээрийг нөхөн сэргээж, Усан хангамжийг 0,1 хувиар нэмэгдүүлнэ.	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр	Тухайн жилд нөхөн сэргээсэн бэлчээр га,	136,6	15,0	Өвөлжөө, хаваржааны дэргэд 43,3 га бэлчээр хашиж, 12,0 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 29,5 мянган га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой тэмцэн нийт 29,6 мянган га бэлчээрийн талбайг нөхөн сэргээгээд байна.	100
			Усан хангамжийг нэмэгдүүлсэн хувь	0,1	0,1	Гүн өрмийн 25 худаг, цооног шинээр гаргаж, энгийн уурхайн 32 худаг сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг 0,1 хувиар нэмэгдүүлсэн.	
9.1	Тэжээлийн ургамал тариалах	Төсөл хөтөлбөр Хувь хөрөнгө-10,0 сая	Тариалах талбайн хэмжээ га	15,1	16	Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Эрдэнэдалай сумдын 17 малчин өрх 12,0 га талбайд тэжээлийн ургамал тариалсан. Нийт 27,1 га талбайд тэжээлийн ургамал тариалаад байна.	100
9.2	Бэлчээр хашиж хамгаалах	хувь хөрөнгө	Тухайн жилд хашсан талбайн хэмжээ га	51,5	10	Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай зэрэг сумдын 21 малчин өрх өөрийн өвөлжөө, хаваржааны дэргэд 43,3 га бэлчээрийн талбайг хашсан.	100
9.3	Гүн өрмийн худгийг шинээр гаргах	Төсөл хөтөлбөр, ОНТ 175.0 сая	Шинээр гаргасан худгийн тоо	10	10	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл, Орон нутгийн төсөв, малчдын хувь хөрөнгө 810,6 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Хулд,	100

						Эрдэнэдалай зэрэг 8-н суманд инженерийн хийцтэй гүн өрмийн 25 худаг, Баянжаргалан, Дэрэн, Хулд, Эрдэнэдалай сумдад 27 цооног бүгд 52 худаг шинээр гаргасан.	
9.4	Энгийн уурхайн худгийг сэргээн засварлах.	Төсөл хөтөлбөр, ОНТ - 15,0 сая	Тухайн жилд Засварласан худгийн тоо	44	45	ОНХС-ийн хөрөнгөөр Баянжаргалан, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Эрдэнэдалай зэрэг 6-н суманд энгийн уурхайн 32 худгийг сэргээн засварласан. Нийт 76 худгийг сэргээн засварлаад байна.	100
9.5	Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулах.	УТ, ОНТ- 30,0 сая	Тухайн жилийн тэмцсэн талбайн хэмжээ /мян га/.	70,0	15,0	Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний А/166 тоот захирамжаар Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар 29,5 мянган га талбайд тэмцсэн	100
9.6	Өвөлжилтийн бэлтгэл хангалт	ОНТ- 500,0 сая	Хувь	80,9 хувь	81	Засгийн газрын 2022 оны 222 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах шалгуур үзүүлэлтийн дагуу Аймгийн Засаг даргын 10 сарын 17-ны өдрийн А/406 тоот захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай танилцсан Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 86,3 хувьтай хангагдсан.	100
9.7	Мал аж ахуйн салбарын нэмүү өртөгийн үнэлэмжийг	Төсөл хөтөлб	Хэрэгжиж эхлэсэн төслийн тоо	0	1	Дэлхийн банкны санхүүжилттэй Эдийн засгийн эргэлтийг	100

	нэмэгдүүлэх хэрэгжүүлэх	төсөл	өр 100,0 сая				нэмэгдүүлэх төсөл хэрэгжиж байна. Төслийн 1-р үе шатны сургалтанд зудын эрсдлийг бууруулах болон даван туулах бэхжүүлэх, чадавхжуулах зорилгоор малчдын бүлгийг чадавхжуулах, малд үзлэг ангилалтыг хийхэд анхаарах, малчид хээлтэгч, хээлтүүлэгч мал сонгоход анхаарах талаар үзүүлэх сургалтыг 2022 оны 04 сарын 18-20-ны өдрүүдэд Дэрэн, Луус, Хулд сумдад нийт 150 малчныг хамруулсан. 2 дахь үе шатны сургалтыг Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд малчид өөрсдийн хороо, бууцны хөлд тэжээлийн ургамал тариалах, үзүүлэх сургалтыг Хулд, Сайнцагаан, Дэрэн сумдын нийт 52 малчныг хамруулан Дэрэн 05 сарын 26-27 өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 3 удаагийн сургалтаар 234 малчныг хамруулсан.	
10	Шинжлэх ухааны дэвшилтэт аргын олотыг нэвтрүүлэх		УТ, ОНТ 46,0	Тухайн жилд дэвшилтэт арга ашигласан малын тоо	16450	2300	Биотехнологийн дэвшилтэт арга болох зохиомол хээлтүүлгийн аргаар 350, битүү хөнгөлгөөний аргаар 680, зохиомол хээлтүүлгээр гарсан төл 380, сүүний чиглэлийн ухнаар 50н ямаанд, олдохын хүрэн буураар 945 ингэнд сайжруулагчаар, Дорнод монголын махны чиглэлийн	100

						өндөр ашигт мухар улаан үүлдрийн бухаар 300 үнээнд сайжруулагчаар ашигласан. Шинжлэх ухааны дэвшилтэт аргыг нийт 2705 малд ашигласан байна	
10.1	Сайнцагаан омог, нутгийн монгол хонинд зохиомол хээлтүүлэг хийх,	ОНТ	Тухайн жилд хээлтүүлэг хийсэн малын тоо,	400	200	Энэ онд Сайнцагаан омгийн хээлтүүлэгч болон, суффлек хуц ашиглан 350 эм хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн.	100
10.2	Баталгаажсан омгийн малд үзлэг ангилалт хийх	УТ, ОНТ 45,0	Тухайн жилд ангилалтанд хамрагдсан малын тоо	16000	2000	Сайнцагаан омгийн хонь 3256, нутгийн монгол хонь 4109, Олдохын хүрэн бор омгийн 3000 тэмээ бүгд 10365 малыг ангилалтанд хамруулсан.	100
10.3	Битүү хөнгөлгөөний аргыг хэрэглэх	ОНТ, хувийн хөрөнгө ө 1,0	Хөнгөлсөн малын тоо	50	100	Битүү хөнгөлгөөний аргаар Сайнцагаан, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Хулд зэрэг сумын 500 хурга, 150 ишиг, бяруу 30 бүгд 680 малд туршсан.	100
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
1	Байгууллагын гадна орчин өнгө үзэмжийг сайжруулах	УТ, ОНТ- 22,3	Тарьсан модны тоо	170	100	Байгууллагын хашаанд 60 ш улиас хайлаас шинээр, төрийн байгууллагуудын хуваарьт талбайд 40 ширхэг улиас хайлаас шинээр болон нөхөн тариалсан.	100
			Зүлэгжүүлсэн талбайн хэмжээ м ²	10	20	Байгууллагын хашаанд нийт 20 м ² талбайд царгас, согоовор тариалж зүлэгжүүлээд байна. Байгууллагын тохижилтод нийт 25,920,000.0 төгрөгийг зарцуулсан.	

1.1	Байгууллагын гадна ангилан ялгах хогийн савтай болох	УТ- 0,3	Хогийн савны тоо	0	1	Орон нутгийн үйлдвэрлэгчээс 900,000 төгрөгний үнэтэй зориулалтын ангилан ялгах хогийн савыг худалдан авч байгууллагын хашаанд байршуулсан.	100
1.2	Хүлэмжийн ашиглалтыг нэмэгдүүлэх	Хувийн хэвшил -1,5	Ашиглалтын хувь	30	50	300 м ² бүхий том хүлэмж, 40 м ² жигжиг хүлэмжийг байгууллага өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тариалалт хийж, 0,6 тн ургац хураан авсан. Байгууллагын хашаанд нийт 13 албан хаагч 0,2 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 0,3 тн ургац хураан авч өөрсдийн өрхийн хэрэгцээгээ хангалаа.	100
1.3	Автомашины гражийн засварыг дуусгах	УТ-20,0	Засварласан эсэх Тийм-1 үгүй-0	0	1	Автограшийн иж бүрэн засварыг тендерт шалгарсан “Мандал шилтгээн” ХХК 25,0 сая төгрөгөөр гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100
2	Худалдаа үйлчилгээний салбарын шинэчилсэн стандартыг мөрдүүлж хэрэгжүүлж ажиллах	УТ, ОНТ, Төсөл хөтөлб өр, Хувийн хэвшил	Стандартын хэрэгжилтийн хувь	95	97	Аймгийн хэмжээнд хүнсний худалдааны чиглэлээр 142 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж эдгээрт 451 хүн ажиллаж байна. Эрүүл аюулгүй тав тухтай орчин бүрдүүлж стандартын шаардлагад нийцүүлсэн худалдааны газар 95 хувьтай байна.	50
2.1	Хоол үйлдвэрлэл MNS 4946:2019, Худалдаа үйлчилгээний салбарт шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгийг мөрдүүлж хэрэгжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлб өр,	Стандартын хэрэгжилтийн хувь	90	95	Аймгийн хэмжээнд хоол үйлдвэрлэлийн салбарт 56 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж эдгээрт 284 хүн ажиллаж байна. Эрүүл аюулгүй тав тухтай орчин	70

		Хувийн хэвшил				бүрдүүлж стандартын шаардлагад нийцүүлсэн хоол үйлдвэрлэлийн газар 92 хувьтай байна.	
3	Газар, тариалан эрхлэгчдэд салбарын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах.	УТ,ОН Т, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Иргэн ААНэгжийн тоо	75	80	Байгууллагын цахим болон facebook хуудсанд цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг 88 тариаланчдад хүргүүлж ажиллалаа. Мөн газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд тариаланч, тариалангийн талбай, ургацыг бүртгэх цахим систем нэвтрүүлэх сургалтыг танхимаар болон цахимаар 30 тариаланч мөн ХААТасгийн мэргэжилтнүүдийг 4 удаагийн давтамжаар сургалтад хамруулсан байна.	100
3.1	Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авсан техник тоног төхөөрөмжийн энэ оны хувиарт төлөлтийг барагдуулах	Хувийн хэвшил	Тухайн жилийн төлөгдөх мөнгөн дүн	2,26 сая төгрөг	1,2 сая төгрөг	2022 онд Сайнцагаан Дэлгэрцогт, Говь-Угтаал сумдын 7 иргэн нь гэрээний дагуу төлөгдөх зээлийн төлбөрийг төлж, суулгац 831 364, хүлэмж-390,000 эргэн төлөлтийг тус тус барагдуулж нийт 1 221 364 /нэг сая хоёр зуун хорин нэг мянган гурван зуун жаран дөрвөн төгрөгийг/ Хөдөө аж ахуйг дэмжих санд төвлөрүүлж, эргэн төлөлт 100 хувьтай байна.	100
4	Жижиг дунд бизнес эрхлэгчдэд салбарын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах.	УТ,ОН Т, Төсөл хөтөлбөр,	Иргэн ААНэгжийн тоо	40	45	Сумдын мэргэжилтэн, ЖДҮҮЭ нарыг хамруулсан 3 удаагийн танхимын, 4 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 60 хүнийг хамруулан мэдлэг олголоо.	100

		Хувийн хэвшил				Мөн 18 ААН, хоршоог Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлж шинээр 7 ААНэгж 6 хоршоо бий боллоо.	
4.1	“Дундговь түншлэл 2022” үзэсгэлэн худалдааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Оролцогчдын тоо	-	95	“Дундговь Түншлэл-2022” үзэсгэлэн худалдааг 9 сарын 15-17 ны өдрүүдэд 18 дахь жилдээ зохион байгуулагдаж нийт 260 гаруй үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд 3 өдөр турш бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах сурталчлах боломжийг олгосноор 145,8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өмнөх жилүүдээс оролцогчийн тоо 57,7 хувь, борлуулалтын орлого 32,8 хувиар өссөн үр дүнтэй байлаа.	100
			Борлуулалтын орлого	-	34,0		
4.2	Мерит төсөлтэй хамтран Уул, уурхайн аж ахуйн нэгжийг орон нутгийн Жижиг дунд бизнес эрхлэгч нартай холбох, хамтын ажиллагааг өргөжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Хамтран ажиллаж буй ЖДҮ бизнес эрхлэгчийн тоо	1	3	Уг ажлын хүрээнд Аймгийн Засаг дарга Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй 24 ААН–тэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулах, үйлдвэрлэлийг өргөтгөх зорилгоор зохион байгуулагдсан 3 удаагийн сургалт, туршлага судлах аялалыг зохион байгуулсаны үр дүнд 7 үйлдвэрлэгч 60,7 сая төгрөгийн ханган нийлүүлэлтийг хийжээ.	100
5	Малчдыг соён гэгээрүүлэх, орон нутгийн брэнд	ОНТ, Төсөл хөтөлбөр	Зохион байгуулсан	0	3	Малчдыг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд нийт 6 арга хэмжээг	100

	бүтээгдэхүүний судалгааны ажлыг эхлүүлэх	өр-100,0 сая	арга хэмжээний тоо			амжилттай зохион байгуулсан байна. Үүнд: 1.Эрдэнэдалай сумын Цавчир багт 40 гаруй малчинд таваарлаг мал сэдэвт мэдээлэл хийсэн. 2.Бүх сумдад малчдын зөвлөгөөн зохион байгуулж нийт 3626 малчин хамрагдсан. 3.Битүү хөнгөлгөөний аргыг малчдад түгээн дэлгэрүүлэхээр Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Хулд, Сайнцагаан сумдын 60 малчинд сургалт явуулсан. 4.Тэжээлийн ургамал тариалах сургалтыг Дэрэн, Хулд, Сайнцагаан сумдын малчны бүлгийн 200 малчинг хамруулсан 5.Дэлгэрхангай суманд тэмээчдийн баярын арга хэмжээ зохион байгуулсан 6. Адаацаг суманд адууны өв соёлын эвент арга хэмжээг АЗДТГ, БОАЖГ, Адаацаг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан.	
5.1	"Тэмээчдийн баяр"-ыг зохион байгуулах	ТББ, ОНТ - 10,0сая	Зохион байгуулагдсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Дундговь аймгийн тэмээчдийн баяр арга хэмжээг Дэлгэрхангай суманд зохион байгууллаа. Тэмээчдийн уламжлалт ёс жаягыг олон нийтэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх тэмээний баяр арга хэмжээнд Хулд, Өлзийт, Дэлгэрхангай, Цогтовоо, Мандаловоо сумдын тэмээчид оролцож 3-н насны тэмээний	100

						уралдаанд 79 тэмээ уралдаж, бурантаг томох, буйл зорох тэмцээн, сайхан тэмээтэй хос шалгаруулах, сайхан буур, сайхан ингэ тус тус шалгарууллаа.	
5.2	“Шилмэл мал-2022” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	ОН-5,0 сая	Зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Улсын шилмэл мал-2022 үзэсгэлэн худалдаа, арга хэмжээ энэ жил анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулагдаж 16 аймаг, нийслэлийн 74 иргэн, 17 аж ахуй нэгжийн 128 толгой мал оролцсноос Өндөршил сумын “Өндөршил” омгийн адуу үржүүлдэг малчин У.Батбилэгийн Хонгор азарга, загал гүү, Хулд сумын “Олдохын хүрэн бор” омгийн тэмээ үржүүлдэг малчин Б.Баянжаргалын хүрэн бор буур, С.Батжаргалын хүрэн бор ингэ, Сайнцагаан сумын Сайнцагаан омгийн хонь үржүүлдэг малчин Ц.Жаргалсайхан, Х.Бүрэн-Амгалан нарын эм хонь, Говь-Угтаал сумын малчин Т.Жаргалсайханы эм ямаа сүүний ямааны төрөлд Улсын гойд ашиг шимт малаар тус тус шалгарсан.	100
5.3	Айргийг аймгийн брэнд бүтээгдэхүүн болгох арга зүй батлуулах	ОН-10,0	Батлуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Айргийг аймгийн брэнд болгох арга зүй батлуулах ажлыг ХААИС-ын багш нартай хамтран судалгаа хийж 2022 оны 06сарын 10-ны өдөр батлуулсан.	100

5.4	Аймгийн аварга шалгаруулах адуучин тэмцээн, айрагны баяр зохион байгуулах	ОН-10,0	Зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Дундговь аймаг нь нүүдэлчин, малчин түмнийхээ “Адууны өв соёлын баяр” эвент арга хэмжээг эртнээс адуун цэг гэгдэж байсан Адаацаг сумын “Сүм хөх бүрд” түүх, соёлын дурсгалт газар 09 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Адууны баяр арга хэмжээнд дотоод, гадаадын жуулчид өргөн дэлгэр оролцож адуу дагасан соёл уламжлалаас суралцаж, гүүний үрс гаргах ёсон, унага тамгалах, хул залах, адууны өв соёл эдлэл хэрэгслийг дэлгэн таниулахаас гадна ардын урлагийн тоглолтыг байгалийн сайханд үзэж сонирхон адуучин тэмцээн, дэмбээ, талын хуруу, айраг уух, бөхийн барилдаан, сайхан хос морьтон уралдаан тэмцээнийг зохион байгуулсан.	100
5.5	Лобраторийн судалгааны ажил хийнэ	ОН-50,0	Судалгаа хийгдсэн эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Дэлхийн банкны санхүүжилттэй МААЭЗЭН төслөөр санхүүжүүлж айрагны лаборатрын судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн боловч УИХ-аас 2022 оны 04 сарын 29-ны өдрийн Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбогдуулан санхүүжилтын ажил зогссон тул лобароторийн судалгааны ажил түр хойшлогдоод байна.	0

6	Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд	Төсөл хөтөлбөр, УТ-10,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	90	Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд 7 заалт бүхий төлөвлөгөө батлуулан 100% хэрэгжүүлэн ажилласан.	100
6.1	Аймгийн тариаланчдын зөвлөгөөн, газар тариалангийн үзүүлэх сургуулилтыг зохион байгуулах	Төсөл хөтөлбөр-5,0	Зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Тэрбум мод "Үндэсний хөдөлгөөн, "Дундговio ногооруулъя" хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан 5 сарын 13,14-ний өдрүүдэд Мандал худалдааны төвийн гадна талбайд зохион байгуулагдсан "Дундговio ногооруулъя" үзэсгэлэн худалдаагаар 1 550 000 төгрөгийн төмс, хүнсний ногооны үр үрсэлгээ, бордоо, арчлах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан борлуулж, нийт 90 тариалан эрхлэгчид зөвлөгөө мэдээлэл өглөө.	100
6.2	Малчдад эрүүл зөв амьдрах арга, ухаан дадал хэвшлийг төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Сумдын малчдын зөвлөгөөнд "Маханд эмийн үлдэгдэл нөлөөлөх нь" сургалтыг 3626 малчинд Малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнд хуванцар савны хэрэглээний талаар 700 малчинд тус тус мэдээлэл хүргэсэн байна.	100
6.3	Мал аж ахуйн салбарт дэлгэрч буй шинжлэх ухааны дэвшилтэт аргыг малчдад түгээн дэлгэрүүлэх	ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн	Малчдын тоо	0	1	Хүний хөгжлийг дэмжих жил, Монгол малчин үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Малчдыг соён гэгээрүүлэх арга хэмжээ малчдын	100

		хэвшил -5,0				зөвлөгөөнийг 04 сарын 26 өдрөөс 05 сарын 27-ны хооронд 15-н суманд холбогдох байгууллагууд хамтран амжилттай зохион байгуулсан. Зөвлөгөөнд нийт 3626 малчин хамрагдсан.	
Зорилтын дундаж хувь 16							89.8
Арга хэмжээний дундаж хувь 48							87,9
Хэрэгжилтийн дундаж хувь							88,9